



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/96

Жаргалтхаан сум

┌ Улсын уралдаан зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/364 тоот захирамж, сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 04 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумаас төрөн гарсан Монгол улсын төрийн дээд шагналт Чингис хаан одонт, Хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравын нэрэмжит “Сэрсэн тал” дуу хөгжмийн наадмын хүрээнд зохион байгуулагдах Орчин үеийн дуу дуулаачдын улсын Гуравдугаар уралдааныг 2025 оны 09 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Орчин үеийн дуу дуулаачдын улсын гуравдугаар уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Отгонбаяр– Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Л.Цэнгэл– Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

нарийн бичгийн дарга

Гишүүд: С.Мөнхдэлгэр – Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Урангоо – Б.Шарав сангийн удирдах зөвлөлийн

гишүүн /зөвшилцсөнөөр/

Д.Чинбат – Ерөнхий боловсролын сургуулийн

захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Өнөржаргал – Цэцэрлэгийн эрхлэгч

Н.Түвшинжаргал – Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Ж.Ариунгэрэл – Соёлын төвийн эрхлэгчийн албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч

Т.Сүрэнцэцэг – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2.

Д.Алтангэрэл – Ерөнхий боловсролын сургуулийн
дуу хөгжмийн багш

Б. Батхишиг – Хэсгийн төлөөлөгч

3.Улсын уралдааны удирдамж, төсөв, төлөвлөгөөг боловсруулан бэлтгэл
ажлыг бүрэн хангаж, уралдааныг чанартай зохион байгуулахыг ажлын хэсэг
(Н.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ